



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Говь консалтинг менежмент ОНӨААТҮГ-ын 2021 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/8/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020

Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа

Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.03.15 № 16/325

танай _____-ны № _____-т

ГОВЬ КОНСАЛТИНГ МЕНЕЖМЕНТ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
П.БЯМБАНАРАНЖАВ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь консалтинг менежмент ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Говь консалтинг менежмент ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	-	2.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		
	Нийт хөрөнгийн дүн	-	2.0
	Нийт өр төлбөрийн дүн	-	15.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	(13.4)
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	2.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	-	69.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	-	84.1
	Үйл ажиллагааны үр дүн	-	(14.3)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	0.1
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-	(14.4)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1.0
	Хуримтлагдсан үр дүн	-	(14.4)
	Эцсийн үлдэгдэл	-	(13.4)
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	-	213.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	-	217.3
	Үйл ажиллагааны ЦМГ	-	(3.7)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	4.9
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	1.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1.2

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говь консалтинг менежмент ОНӨААТҮГ-ын зорилго нь Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар ажиллах төсөл хэрэгжүүлэгч талтай орон нутгаас хамтран ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллага нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна гэжээ.

Үүнд:

- Ажил түр эрхлүүлэх агентлагийн үйл ажиллагаа
- Хүний нөөцөөр хангах болон хүний нөөцийн менежментийн үйл ажиллагаа
- Туслах үйл ажиллагаа

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар” гэсэн статустай байна. Өмчийн 100 хувь орон нутгийн өмч байна.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6.9-д “10 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв,..... төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа Аж ахуйн нэгж байгууллага нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно” гэж заасны дагуу шалгахад ямар нэгэн асуудал, зөрчил илрээгүй байна.

3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 153.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 143.7 сая төгрөгийн алдааг залруулж, 9.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

5.1 Залруулсан алдаа

Орлогын дэлгэрэнгүй тайланд 143.7 сая төгрөгийн борлуулалтын орлого илүү тайлагнасан алдааг залрууллаа.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **НББББ-тэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын хэмжээнд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь бүртгэлийн акруэл суурийг мөрдөхгүй байх, хөрөнгө, өр төлбөр, орлого зардлыг хүлээн зөвшөөрөх зарчим алдагдах, НББ-ийн үе шатуудад гүйцэтгэх ёстой ажиллагаанууд дутуу хийгдэх г.м эрсдэлүүд үүсгэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 18.1 дэх заалтад "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2 дахь заалтад "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасны дагуу байгууллагын хэмжээнд НББ-ийн бодлогыг боловсруулж, тууштай мөрдөх.

2. Зорилтот түвшин, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулаагүй, батлуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлийн 2.3-д заасны дагуу "... үндсэн хөрөнгийг ... шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жил бүр эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, худалдан авалт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөө боловсруулж, эрх бүхий дээд шатны байгууллагаар батлуулж, мөрдөж ажиллах.

3. Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд ажилласан 19 иргэнээс 18 иргэнтэй нь "Хөлсөөр ажиллах гэрээ"-г байгуулсан, нийтдээ 36.2 сая төгрөгийн ажлын хөлс олгосон ба түүнд ногдох ажил олгогч, даатгуулагчаас төлөх 9.3 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, тайлагнаагүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1-д "хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна", 32.1.2-д "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс", 16 дугаар зүйлийн 16.4 "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн шимтгэл төлөх тооцоог тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч гүйцэтгэнэ", 17 дугаар зүйлийн 17.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах.

4. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2021 онд аж ахуйн нэгж байгууллагуудаас и-баримтгүй 61.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.14-т "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг", 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим и-баримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

5. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Валютаар хийсэн ажил гүйлгээг бүртгэлд тусгахдаа Монгол банкны валютын албан ханшаар тооцоогүй нь “Валютын зохицуулалтын тухай” хуулийн 5.5-д “эдийн засгийн харьяат болон харьяат бусын гадаад валютаар олсон орлого, импортын барааны хилийн үнийг төгрөгт шилжүүлэн гаалийн болон бусад татвар ногдуулах хэмжээг тодорхойлох, гадаад валютаар илэрхийлэгдсэн аливаа хөрөнгө, эх үүсвэрийг нягтлан бодох бүртгэлд төгрөгөөр илэрхийлж тусгахад Монголбанкнаас зарласан тухайн өдрийн албан ханшийг баримтална” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Валютын ханшийг Монгол банкнаас зарласан тухайн өдрийн албан ханшийг баримтлан нягтлан бодох бүртгэлд бүртгэх

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨААТҮГ	+	+			+			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ОНӨААТҮГ	6	153.0	1	143.7					5	9.3
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ ДҮН	6	153.0	1	143.7					5	9.3